

7. ЗӨГИЙН БҮЛИЙН НАМРЫН АРЧИЛГАА МАЛЛАГАА (8-10 ДУГААР САР)



7-1. Зөгийн бүлийн хүчийг хадгалах	125
7-2. Өвөлжих зөгий олноор бий болгох	126
7-3. Хачгийн халдварыг хянах, эмчлэх	126
7-4. Бүлийн давхрыг буулгах	127
7-5. Зөгийн бүлд өвөлжих тэжээл олгох	128

7-1. Зөгийн бүлийн хүчийг хадгалах

Жил бүр харилцан адилгүй боловч дунджаар 8 дугаар сарын сүүлч 9 дүгээр сарын эхнээс (ойролцоогоор намрын дунд сарын эхэн) зөгийн бүлийн хүч аажмаар суларч эхэлдэг. Энэ нь гадна орчны температур болон балт ургамлын цэцэглэлт буурсантай холбоотой. Зөгийн аж ахуй нь хавраас зун хүртэл бал хураах бүлийг үржүүлж, тогтвортой хадгалж бал хураана. Зун нь бүл салгаж шинэ эх зөгий болон шинэ бүл бий болгох үйл ажиллагаа үргэлжлэх бол, харин намар нь зөгийгөө өвөлжихөд бэлтгэдэг.


Бүлийн хүчийг хадгалахын тулд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

- Бүлд уурагт тэжээлийн нөөц (цэцгийн тоос), амтат шүүс хүрэлцээтэй эсэхийг хянаж дутагдалтай гэж үзсэн тохиолдолд тэдгээрийг олгох
- Өндөглөлт явагдаж буй ташаалавчны эргэн тойрныг бага зэрэг эвдэх аргаар эх зөгийд өндөглөх ташаалавч нэмж өгөх
- Зөгийн бүлийг шахах, нийлүүлэх
- Хачгийн халдварыг хянах, эмчлэх
- Бүлийг намар орой хучиж дулаалах

Тэжээлийн нөөцийг хянах олгох:

Балт ургамлын цэцэглэлт буурснаар цэцгийн тоос ховордож улмаар өндөг үрвэлдэйг тэжээх сүүнцрийн хэмжээ багасна. Мөн амтат шүүс ховордож эхэлдэг. Зөгийн бүл тэжээлгүйдэх үед доорх арга хэмжээг авах шаардлагатай.

- Цэцгийн тоостой жааз хүрэлцээтэй эсэхийг шалгаад дутагдалтай гэж үзсэн тохиолдолд цэцгийн тоостой нөөцөлсөн жааз, эсвэл үйлдвэрийн аргаар боловсруулсан уурагт тэжээл, мөн зун хураасан цэцгийн тоосоор тэжээл бэлтгэн өгнө (Уурагт тэжээл бэлтгэх олгох тухай 4-1-3 хэсгээс эргэн үзнэ үү.).
- Намрын эхэн, дунд үед үргэлжилсэн бороо ороход зөгий хоолгүйдэх тохиолдол үүсвэл өл залгах хэмжээгээр бага зэрэг 1:1 харьцаатай сахарын уусмалаар тэжээж болно.
- Балт ургамал (рапс) тариалсан талбайд намар оторлох эсвэл намар орой цэцэглэж байхаар тооцож балт ургамал зөгийн аж ахуйд зориулж бага зэрэг тариалах



Байгалийн цэцгийн тоос ховордсон үед таримал ургамлын цэцгийн тоос авахуулах нь зөгийн бүлийн уургийн хэрэгцээг хангахад маш чухал ач холбогдолтой.



6-р сарын 27-ны өдөр тариалсан **гич** (*Sinapis arvensis*, L), **морин дэл** (*Phacelia tanacetifolia*)-ийн цэцэг 9-р сарын 03-ны байдлаар

Рапсын талбай

7-2. Өвөлжих зөгий олноор бий болгох

Зөгий дунджаар нэг сар орчим насалдаг бол өвөлжих зөгий илүү удаан насалдаг бөгөөд хавар шинээр төрсөн үрвэлдэйг бойжуулж өгөөд залуу зөгийд халаагаа өгдөг. Ийнхүү илүү урт насалдаг шалтгаан нь тэдний биед өөхөн эд хуримтлагдаж урт хугацаанд зарцуулагдах энергийн эх үүсвэр болдог байна.

Тухайн жилийн зун нь үржилд орсон залуу эх зөгий өмнөх жилийн эх зөгийтэй харьцуулахад харьцангуй олон тооны өвөлжих зөгийг төрүүлж чаддаг.

Намрын зөгийн энергийн эх үүсвэрийг хамгаалахын тулд зуны төгсгөл намрын эхнээс тэжээлийн нөөцийг тогтмол хянах, варроа хачгийн халдварлалт огцом ихсэхээс сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх нь чухал.

7-3. Хачгийн халдварыг хянах, эмчлэх

Варроа хачгийн халдвар зун, намрын улиралд хэт их байснаас зөгийн дархлаа сулран гадны жаахан таагүй нөлөөнд (үнэр гэх мэт) мэдрэмтгий болно. Иймээс бие гүйцсэн ажлын зөгий гэнэт алга болох буюу дайждаг.

Манай зөгийчид намар зөгий гэнэт цөөрсөн, дайжсан тухай, мөн хавар өвөлжөөнөөс зөгий гаргахад хоосон үүр хайрцаг гарч ирсэн тухай ярьцгаадаг.

Иймээс хачгийн халдварын түвшинг намар эрт тогтоож арга хэмжээ авах тухай 9-5-5 хэсгээс, мөн эмийн бус аргаар (хачгийн занга бэлтгэх) варроа



хачигтай тэмцэх тухай 9-5-4 хэсгээс уншина уу.

Зөгийн бүлийн хүч суларч байхад варроа хачгийн халдварлалт эрчимтэй нэмэгдэж байгааг графикаар харуулсан байна. Иймээс хаврын эмийн эмчилгээг үр дүнтэй хийх, мөн зуны улиралд хачиг ажиглагдвал халдварлалтын түвшинг тогтоож зохих арга хэмжээ авах, хачгийн занга бэлтгэх шаардлагатай.

7-4. Бүлийн давхрыг буулгах

Хэзээ:

Өвөлжих зөгийн хүчийг сааруулахгүй байх зорилгоор амтат шүүс ховордсон үе буюу 8 дугаар сарын сүүлээс 9 дүгээр сарын эхэн үед цуглуулж буй балыг авахгүй байх нь чухал юм.

Энэ хугацаанд буюу отрын бэлчээрээс оруулж ирээд бага ч болов бал цуглуулж байх үед нь бүлийн давхрыг буулгана.

Юу хийх:


Доод давхарт үзлэг хийж балтай тэжээлийн жааз хүрэлцэхүйц хэмжээгээр байгаа эсэхийг шалгаад шаардлагатай бол дээд давхрын балтай жаазнаас авч өгнө.

Мөн өндөг, үрвэлдэйгүй хоосон жааз байвал хасаж авна.

Дараа нь дээд давхрын жаазан дээр байгаа зөгийг доод давхар луу шүүрдэж нийлүүлэх ба тэнд байгаа балтай жаазыг өвөлжих тэжээл олгох хүртэл тухайн бүл болон бусад бүлд ээлж дараалан тавьж өгөхөөр нөөцөлж авна.

Ингэж нэг дан болсон бүлийг дунд хэсэгт нь нялх өндөг үрвэлдэйтэй, түүний хажууд шинээр өндөглөх ташаалавч бүхий жааз, түүний гадна талд хаалттай үрвэлдэй, захад нь тэжээлтэй (цэцгийн тоос болон бал) жааз байхаар байрлуулна.


Зөгийн бүлийн давхрыг буулгах, тэжээх үеийн ерөнхий дараалал:



Зөгийн бүлийн давхрыг буулгах үед анхаарах зүйл:

- Дан болгож буй бүлийн зөгийн хүчинд нь тааруулж жаазны тоог тохируулах ба ханхайдуулж болохгүй (жаазыг цөөлж зөгийн нягтаршлыг нэмэх тухай 4-2-3 хэсгээс харна уу.).
- Хэрэв давхар буулгаж байгаа бүл нь их хүчтэй бөгөөд өндөг үрвэлдэйтэй жаазны тоо олон бол эдгээрээс цөөн тоогоор өөр сул хүчтэй бүлд өгч дэмжиж болно.
- Эсрэгээрээ давхар буулгаж байгаа бүлд өндөг үрвэлдэйтэй жаазны тоо хэт цөөн байвал энэ бүлд уурагт тэжээл нэмэлтээр өгөх шаардлагатай.
- Дан болгосон бүлийн өндөг үрвэлдэйтэй жааз, тэжээлтэй жаазны тоо болон нэмэлт уурагт тэжээл олгосон эсэхийг бүртгэж хөтлөх нь дараагийн үзлэг хийхэд тус болдог.
- Давхар буулгах үед тухайн бүлд тэжээл (балтай жааз) хүрэлцэхгүй байгаа бөгөөд нөөцөлсөн тэжээлтэй жааз байхгүй бол 2:1 сахарын уусмал олгох хэрэгтэй.
- Давхар бүлүүдийг буулгах энэ үед сул хүчтэй буюу биеэ дааж өвөлжиж чадахааргүй бүлийг давхрыг буулгасан бүлтэй нийлүүлэх нь чухал юм. Хэрэв хачгийн халдвар ихтэй улмаас суларсан бүл бол нийлүүлэх шаардлагагүй.

Зөгийн бүлийн давхрыг буулгах, тэжээх үеийн ерөнхий хугацаа:



7-5. Зөгийн бүлд өвөлжих тэжээл олгох

Зөгий өвөлжихдөө тайван (биологийн хувьд идэвхгүй) байдалд ордог ба үүний өмнө сайтар тэжээгдсэн байх шаардлагатай. Мөн өвөлжилтийн сүүлийн сард аажмаар идэвхжиж тэжээл авах шаардлагатай болдог. Иймээс зөгийчин бид тэжээл сайн авахуулж мөн хангалттай нөөцлүүлээд өвөлжөөнд оруулах шаардлагатай.

Ийм зорилгоор өгч буй 2:1 харьцаатай сахарын уусмал нь өвөлжүүлэх тэжээл юм.

Сахарын уусмал бэлтгэхдээ ...

- Нэг бүл зөгийг тэжээхэд 6-8 кг элсэн сахар орохоор тооцно.
- Элсэн сахарыг буцлам халуун усанд 2:1-ийн харьцаагаар бага багаар хийж сайтар хутгаж уусгана.

- Энэ сахарын уусмалд эм, витамин зэрэг бусад зүйл хольж болохгүйг анхаарна уу.

Өвөлжих тэжээл олгох:

Бэлтгэсэн сахарын уусмалыг идүүрт хийж өгөх ба бүлийн хүчнээс шалтгаалж харилцан адилгүй хугацаанд мөн харилцан адилгүй хэмжээгээр өвөлжих тэжээл бүлд нөөцлөгддөг. Тухайлбал, 2-2.5 л багтаамжтай идүүр ашиглаж буй тохиолдолд хүч сайтай бүл дунджаар 3 удаагийн тэжээлтээр 6-7 жаазанд өвөлжих тэжээл нөөцөлдөг.



Модон идүүрээр тэжээж байгаа бол түүний зэргэлдээх сахарын тэжээл дүүрэн хуримтлагдсан жаазыг эсрэг зах руу шилжүүлэх байдлаар богино хугацаанд жаазнуудад жигд нөөцлөх боломж бүрдүүлнэ.

Жаазан дээр тавьдаг хуванцар идүүр нь зөгий живж үхдэггүй, сахарын уусмал амар царцахгүй, цэвэрлэхэд хялбар зэрэг давуу талтай байдаг.

Өвөлжих тэжээл бэлтгэхэд анхаарах зүйл:

- Рапсын балтай өвөлжүүлэхэд эрсдэл байгаагүй боловч гурвалжин будааны балтай өвөлжүүлэхэд зөгийн бүл олноор хорогдсон тохиолдол байдаг.
- Энэ сахарын уусмалд эм, витамин зэрэг бусад зүйл хольж болохгүйг дахин анхаарна уу.
- Бэлтгэсэн сахарын уусмалыг ил задгай тавихгүй.



